# “ФҮЖИБИТ” ХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР: 6175724/

**УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН**

## АГУУЛГА


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 4
1.1. Төслийн нэр ... 4
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага ... 4
1.3. Төслийн байршил ... 4
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи ... 5
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 9
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт ... 9
2.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ... 13
2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт ... 15
2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт ... 16
2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 17
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 18
ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 22
ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 23
5.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ ... 23
5.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ ... 25
5.3. Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ ... 26
ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 30
6.1. Энгийн хог хаягдлын менежмент ... 30
6.1.1. Хатуу хог хаягдал ... 30
6.1.2. Ахуйн шингэн хаягдал ... 31
6.2. Аюултай хог хаягдлын менежмент ... 31
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ... 33
7.1. Агаарын чанарын хяналт, шинжилгээ ... 34
7.1.1. Судалгааны аргазүй ... 34
7.1.2. Судалгааны үр дүн ... 36
7.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ ... 37
7.2.1. Судалгааны аргазүй ... 37
7.2.2. Судалгааны үр дүн ... 38
7.3. Усны чанарын хяналт шинжилгээ ... 40
7.3.1. Судалгааны аргазүй ... 40
7.3.2. Судалгааны үр дүн ... 43

НАЙМ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........... 45
ЕС. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 48
ХАВСРАЛТ ........ 49

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил ........ 4
Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн бүдүүвч ........ 5
Зураг 3. Гаалийн хяналтын талбай ........ 6
Зураг 4. Авто машины зогсоол ........ 6
Зураг 5. Харуулын байр ........ 7
Зураг 6. Гаалийн хяналтын талбайн салхины хаалт ........ 7
Зураг 7. Авто пүү /SCS 200T/, дугуйт ачигч /SEM 656D/ ........ 7
Зураг 8. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал ........ 8
Зураг 9. 9702 УН авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр ........ 9
Зураг 10. 9701 УН авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр ........ 10
Зураг 11. 4807 УН суудлын машины үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр ........ 11
Зураг 12. 4806 УН  авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр ........ 11
Зураг 13.Хучилтын тавчан, хучилт хийж буй нүүрс тээврийн хэрэгсэл ........ 12
Зураг 14. Салхинаас хамгаалах хашаа ........ 12
Зураг 15. Зам талбай усалж буй байдал ........ 13
Зураг 16. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав ........ 14
Зураг 17. Ачилт буулгалтын талбайн хучилт хийж дагтаршуулсан байдал ........ 14
Зураг 18. Орц гарцны хэсгийг дагтаршуулсан байдал ........ 15
Зураг 19. Төслийн талбайн тэмдэг тэмдэглэгээ ........ 15
Зураг 20. Ажилчдын кемпийн ногоон байгууламж байгуулсан байдал ........ 16
Зураг 21. Ус хэмнэх анхааруулга хадсан байдал ........ 17
Зураг 22. Ажилчдын кемп болон гаалийн хяналтын талбайн гадна хогийн цэг ........ 17
Зураг 23. Ногоон байгууламж ........ 18
Зураг 24. Модны усалгаа арчилгаа хийж буй нь ........ 19
Зураг 25. Төслийн талбайд байршуулсан гэрэлтүүлэг ........ 19
Зураг 26. Ажилчдын кемпийн явган хүний зам талбай ........ 20
Зураг 27. Бүх нийтийн хог цэвэрлэгээ хийж буй байдал ........ 21
Зураг 28. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө ........ 23
Зураг 29. Онцгой байдлын сургалт зохион байгуулж буй байдал ........ 24
Зураг 30. Давтан зааварчилгаа ........ 24
Зураг 31. Галын сарай, гал унтраах багаж хэрэгсэл байрлуулсан байдал ........ 25
Зураг 32. Галын аюулгүй байдлын дүгнэлт ........ 26
Зураг 33. ХАБЭА-н зааварчилгаа өгч буй байдал ........ 26
Зураг 34. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэл ........ 27

Зураг 35. Анхны тусламжийн хэсэг....28
Зураг 36. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө....28
Зураг 37. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олгосон байдал....29
Зураг 38. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав....30
Зураг 39. Ажилчдын кемп болон гаалийн хяналтын талбайн гадна хогийн цэг....31
Зураг 40. Ахуйн бохир шингэн хаягдлын худаг....31
Зураг 41. Эмнэлгийн хог хаягдал....32
Зураг 42. Мониторингийн цэгүүдийн байршил....33
Зураг 43. Хээрийн судалгааны багаж....34
Зураг 44. Агаарын мониторингийн цэг....35
Зураг 45. Агаарын чанарын шинжилгээ хийсэн хэсэг /6 болон 9-р сар/....36
Зураг 46. Хөрсний мониторингийн цэгийн байршил....38
Зураг 47. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Ачилт буулгалтын талбайд 6 болон 9-р сар/....38
Зураг 48. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Авто зогсоолын ойролцоо 6 болон 9-р сар/....39
Зураг 49. Усны мониторингийн цэгийн байршил....41
Зураг 50. Усны дээжлэлт хийсэн хэсэг /2024 оны 06 болон 09-р сар/....41
Зураг 51. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө....45
Зураг 52. ХАБЭА-н сургалтын цахим систем....46
Зураг 53. Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийсэн байдал....47

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд....4
Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил....33
Хүснэгт 5. Агаарын чанарын мониторингийн цэг /Гадаад орчин/....35
Хүснэгт 6. Агаарын шинжилгээний лабораторийн сорилтын дүн....36
Хүснэгт 7. Хөрсний мониторингийн цэгийн солбицол....37
Хүснэгт 8. Хөрсний химийн үндсэн шинж....39
Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд....40
Хүснэгт 10. Усны мониторингийн цэгүүдийн координат....42
Хүснэгт 11. Усны шинжилгээний аргачлал....42
Хүснэгт 12. Шинжлэх аргын стандарт....42
Хүснэгт 13. Усны химийн шинжилгээний үзүүлэлтүүд....43
Хүснэгт 14. Ахуйн бохир усны химийн үзүүлэлтүүд....44
Хүснэгт 15. 2024 онд зарцуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал....48

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн нэр

“Гаалийн хяналтын талбай” төсөл

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Фүжибит” ХХК
Улсын бүртгэлийн дугаар 000212415
Регистрийн дугаар 617724
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Баянмонгол, 412-122 тоот.
Утас: 99138170 /Байгаль орчны мэргэжилтэн/

## 1.3. Төслийн байршил

Гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт, Хайрхан багийн нутагт хилээс хойш 20 км-т оршино. Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд Цагаан хаданд 13.6 га талбайг хамран байрлаж байна. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 1. Төслийн талбайн байршил**

Гаалийн хяналтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд**

| № | X | Y | Талбайн хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | 707784.99 | 4717748.61 | 13.6 га |
| 2 | 707682.24 | 4717921.97 | |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | 707787.23 | 4717991.68 | |
| **4** | 708201.03 | 4718267.33 | |
| **5** | 708325.79 | 4718070.34 | |

## 1.4. Төслийн хүчин чадал, техник технологи

### 1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

“Фужибит” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5-р багийн нутаг Гашуун сухайт хилийн боомтод түшиглэн байгуулагдсан Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх нүүрсийг хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулан ажиллж байна. Гаалийн хяналтын бүсдээ хилийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайнууд болон Эрдэнэс Таван толгой компаний олборлосон экспортын зориулалттай нүүрсийг уурхай дээрээс нь уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийлгэн ачуулж Ханги хилийн боомт руу явуулах үйл ажиллагаа эрхэлж байна.

Хоногт 80-100 автомашин буюу 11200-14000 тонн түүхий эд хүлээн авч буулгах, мөн хэмжээний ачааг ачиж гаалийн хяналт хийлгэнэ. Жилд 315 хоног ажиллаж 3,5 сая тонн уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн экспортонд гаргах хүчин чадалтай.




**Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн бүдүүвч**

Гаалийн хяналтын талбай нь авто пүү, пүүний байр, оффис, харуулын байр, нүүрс ачилт буулгалтын хэсэг, чингэлэг ачилт буулгалтын хэсэг, камер, гэрэлтүүлэг зэргээс бүрдэнэ.

2024 онд 350 мянган тн нүүрс экспортлохоор төлөвлөн ажиллаж байна.




**Зураг 3. Гаалийн хяналтын талбай**

Энэхүү гаалийн хяналтын талбай нь нийтдээ 13.6 га талбайтай бөгөөд задгай нүүрс буулгах талбайн хэмжээ 200 м x 600 м бөгөөд 1 удаад хүлээн авах нүүрсний хэмжээ 6000 тн, чингэлэг буулгах талбайн хэмжээ 200м x 200м, 1 удаад 168 чингэлэг хүлээн авах хүчин чадалтай.



**Зураг 4. Авто машины зогсоол**

“Фүжибит” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан баг, Цагаан хаданд байрлах гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааг “Талын цэнхэг трейд” ХХК-тай байгуулсан FJBT20221011 тоот менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу явуулж байна.

- “Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын талбайн зохион байгуулалтыг хариуцах, шаардлагатай мэргэжлийн ажилтнуудыг хөлслөн ажиллуулах,
- Талбайн тоног төхөөрөмж болон бусад эд зүйлс, эд хөрөнгийг зөв зохистой ашиглах
- Талбайн үйл ажиллагаа, менежментийг хариуцан ажиллана.



**Зураг 5. Харуулын байр**



**Зураг 6. Гаалийн хяналтын талбайн салхины хаалт**

Гаалийн хяналтын талбайд ашиглах техник тоног төхөөрөмжийн хувьд 4 ширхэг дугуйт ачигч, 200 тн-ын даацтай авто пүү 1 ширхэгийг байрлуулан үйл ажиллагаа явуулж байна.




**Зураг 7. Авто пүү /SCS 200T/, дугуйт ачигч /SEM 656D/**

“Талын цэнхэг трейд” ХХК нь ашиглаж буй эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ арчилгааг хугацаанд нь хийлгэнэ.




**Зураг 8. Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал**

### 1.4.2. Төслийн дэд бүтцийн шийдлийн мэдээлэл

***Цахилгаан хангамж.*** Гаалийн хяналтын талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг төвийн эрчим хүчний системээс хангадаг.

***Дулаан хангамж.*** Дулаан хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо Ханбогд сумын цаг уурын үзүүлэлт, оффисын барилгын овор хэмжээ, дулаан хэрэглэгчид болон тэдгээрийн үндсэн зориулалт тавигдах шаардлагын дагуу халаалтыг цахилгаан тень ашиглан хангаж байна.

***Ус хэрэглээний эх үүсвэр.*** Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаа явуулахдаа зөөврийн ус авч ашиглана. Талбайгаас 3 км байрлах худгаас гар нүүр угаах ахуйн хэрэглээний усаа авдаг, харин ундны усыг Ханбогдын нэгдсэн цэвэр усны савалгаатай усыг ашигладаг.

***Зам:*** Гаалийн хяналтын талбай нь Гашуунсухайт хилийн боомт хүртэл 19 км зайд оршино. Мөн Гашуунсухайт-Цогтцэций чиглэлийн авто замаас 120 м зайд байрлаж байна.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төсөлд ашиглаж буй машин механизмууд, тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж жил бүрийн техникийн үзлэг оношлогоонд хамруулж агаарын бохирдлын төлбөрийг төлж ажиллаж байна.


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical description
Улсын дугаар 9702УН
Марк, модель CAT SEM660D
1.00
Зориулалт авто ачигч
Үйлдвэрлэсэн он 2018
Арлын № SEM00660TS6200994
Өнгө Шар
Импортлогдсон огноо 2018/03/28
MGL
Өмчлөгч ИТАЙКАР ХХК
Хаяг Өмнөговь Цогтцэций
Өөрчилсөн тэмдэглэл
Revised note
Тусгай тэмдэглэл
Additional note
№ 01902806
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ
VEHICLE INSPECTION REPORT

**Татвар, хураамж**

Төлөөгүй | Төлсөн

**Тээврийн хэрэгсэл**
Улсын дугаар 9702УН
Загвар SEM 660B
Үйлдвэрлэсэн он 2018

| Он | Дэлгэрэнгүй | | | Нийт дүн | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 2024 | АТБӨЯХТатвар: 16,800₮ | АБТөлбөр: 9,500₮ | АЗАТөлбөр: 5,000₮ | 31,300₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБӨЯХТатвар: 16,800₮ | АБТөлбөр: 9,500₮ | АЗАТөлбөр: 5,000₮ | 31,300₮ | Төлөгдсөн |
| 2021 | АТБӨЯХТатвар: 16,800₮ | АБТөлбөр: 9,500₮ | АЗАТөлбөр: 5,000₮ | 31,300₮ | Төлөгдсөн |
| 2020 | АТБӨЯХТатвар: 16,800₮ | АБТөлбөр: 9,500₮ | АЗАТөлбөр: 5,000₮ | 31,300₮ | Төлөгдсөн |
| 2019 | АТБӨЯХТатвар: 16,800₮ | АБТөлбөр: 0₮ | АЗАТөлбөр: 0₮ | 16,800₮ | Төлөгдсөн |
| 2018 | АТБӨЯХТатвар: 12,600₮ | АБТөлбөр: 0₮ | АЗАТөлбөр: 0₮ | 12,600₮ | Төлөгдсөн |

**Зураг 9. 9702 УН авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр**






## Татвар, хураамж

Төлөөгүй | Төлсөн

**Тээврийн хэрэгсэл**

| | |
|---|---|
| Улсын дугаар | 9701УН |
| Загвар | SEM 660B |
| Үйлдвэрлэсэн он | 2018 |

| Он | Дэлгэрэнгүй | | | Нийт дүн | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 2023 | АТБӨЯХТатвар: 35,904 ₮ | АБТөлбөр: 1,800 ₮ | АЗАТөлбөр: 20,000 ₮ | 57,704 ₮ | Төлөгдсөн |
| 2022 | АТБӨЯХТатвар: 35,904 ₮ | АБТөлбөр: 1,800 ₮ | АЗАТөлбөр: 20,000 ₮ | 57,704 ₮ | Төлөгдсөн |
| 2021 | АТБӨЯХТатвар: 35,904 ₮ | АБТөлбөр: 1,800 ₮ | АЗАТөлбөр: 20,000 ₮ | 57,704 ₮ | Төлөгдсөн |

**Зураг 10. 9701 УН авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр**



**Татвар, хураамж**

Төлөөгүй | Төлсөн

**Тээврийн хэрэгсэл**

Улсын дугаар 4807УН
Загвар SEM 655D
Үйлдвэрлэсэн он 2018

| Он | Дэлгэрэнгүй | | | Нийт дүн | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 2024 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2021 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2020 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2019 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 0 ₮ | АЗАТөлбөр: 0 ₮ | 16,800 ₮ | Төлөгдсөн |
| 2018 | АТБӨЯХТатвар: 15,400 ₮ | АБТөлбөр: 0 ₮ | АЗАТөлбөр: 0 ₮ | 15,400 ₮ | Төлөгдсөн |

**Зураг 11. 4807 УН суудлын машины үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр**




**Татвар, хураамж**

Төлөөгүй | Төлсөн

**Тээврийн хэрэгсэл**

Улсын дугаар 4806УН
Загвар SEM 655D
Үйлдвэрлэсэн он 2018

| Он | Дэлгэрэнгүй | | | Нийт дүн | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| 2024 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2023 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2021 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 9,500 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 31,300 ₮ | Төлөгдсөн |
| 2020 | АТБӨЯХТатвар: 0 ₮ | АБТөлбөр: 0 ₮ | АЗАТөлбөр: 5,000 ₮ | 5,000 ₮ | Төлөгдсөн |
| 2019 | АТБӨЯХТатвар: 16,800 ₮ | АБТөлбөр: 0 ₮ | АЗАТөлбөр: 0 ₮ | 16,800 ₮ | Төлөгдсөн |
| 2018 | АТБӨЯХТатвар: 15,400 ₮ | АБТөлбөр: 0 ₮ | АЗАТөлбөр: 0 ₮ | 15,400 ₮ | Төлөгдсөн |

**Зураг 12. 4806 УН  авто ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн А/199 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам”, Авто тээврийн тухай хуулийн 17-р зүйлд зааснаар Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно гэж заасны дагуу “Фүжибит” ХХК-ийн нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, автомашинуудыг үзлэг оношлогоонд хамруулсан болно.

Агаарт тоосжилт тархахаас урьдчилан сэргийлж нүүрс тээврийн машиныг тээвэрлэлтийн явцад машины тэвшийг хучих, нүүрс унахаас сэргийлж ажиллаж байна. Гаалийн хяналтын талбайн хучилтын тавцанг байгуулсан бөгөөд дараах зургаар харуулав.




**Зураг 13.Хучилтын тавчан, хучилт хийж буй нүүрс тээврийн хэрэгсэл**

“Фүжибит” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн Нүүрс тээвэрлэх, ачих, буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоос, тоосжилт үүсэхээс сэргийлж тоосжилт бууруулах 8 м-ийн өндөртэй зориулалтын хашааг талбайг тойруулан барьж, тогтмол засварлаж, бүрэн бүтэн байдалд хяналт тавин ажиллаж байна.




**Зураг 14. Салхинаас хамгаалах хашаа**

Зам талбайн усалгааны зориулалтын автомашинаар тоосжилт үүсгэж буй зам талбайн тоосжилтыг дарах усалгааг төслийн ачилт буулгалтын талбай болон орц гарцны хэсэгт усалгаа хийж байна.



**Зураг 15. Зам талбай усалж буй байдал**

## 2.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Хог хаягдлаар газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдохоос урьдчилан сэргийлж хаягдлын цэгийг хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай ангилдаг хогийн сав сонгож ашиглалтанд оруулсан.

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиварын үйлдвэрт тушаахаар зориулалтын түр хадгалах саванд хадгалж, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах арга хэмжээг авч ажиллаж байна.



**Зураг 16. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав**

Төслийн ачиж буулгах талбайн хэсгийг хайрган хучилттай болгож, нягтаршуулж, дагтаршуулж ухмал болон дүүргэлтийн материалаар тэгш дайрган хучилттай талбай бэлдэх ажлыг гүйцэтгүүлсэн.



**Зураг 17. Ачилт буулгалтын талбайн хучилт хийж дагтаршуулсан байдал**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Хайрхан багийн Цагаан хаданд байрлах “Фүжибит” ХХК-ийн гаалийн хяналтын талбайн орц гарцны хэсэгт 28,263 $м^2$ хэмжээтэй 25 см зузаантай шороо дэвсэж талбайг тэгшлэх болон 30 м өргөнтэй уулзвар гарц хийх ажлыг “Хөвсгөл сүлд” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгүүлсэн.



**Зураг 18. Орц гарцны хэсгийг дагтаршуулсан байдал**

### 2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

Эзэмшил талбайн дундах зам, нүүрс ачих буулгах талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох 5 км/цаг (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй) шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлсэн.




**Зураг 19. Төслийн талбайн тэмдэг тэмдэглэгээ**

Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтохоос сэргийлж үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлж, даган мөрдөж байна.

“Фүжибит” ХХК-ийн гаалийн хяналтын талбайд ногоон байгууламж байгуулах боломжгүй бөгөөд тээврийн компани болон менежмент хариуцаж буй “Талын цэнхэг трейд” ХХК-ийн ажилчдын кемпийн талбайд ногоон байгууламж байгуулан арчилгаа усалгаа хийж ажиллаж байна.



**Зураг 20. Ажилчдын кемпийн ногоон байгууламж байгуулсан байдал**

## 2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэхээс сэргийлэх зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсанаар унд, ахуйн хэрэглээний усан хангамж, унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна. Лабораторийн шинжилгээний үр дүн болон дэлгэрэнгүй мэдээллийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсгээс харна уу.

Ажилчдын хэрэглээнд гүний усыг ариг гамгүй ашигласнаар усны нөөцөд нөлөөлөх сөрөг нөллийг бууруулах зорилгоор усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааны мэдээллийн хуудсыг гаалийн хяналтын зарын самбар, мэдээллийн самбарт байрлуулж шинэчилдэг бөгөөд ус хэрэглэдэг ариун цэврийн өрөөнд байнга сануулга нааж анхааруулж байна.



**Зураг 21. Ус хэмнэх анхааруулга хадсан байдал**

Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвч болон усан орчин бохирдохоос сэргийлж Дэлгэрэнгүй мэдээллийг хог хаягдлын менежментийн хэсэгт оруулсан болно.

## 2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас нохой, муур тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй тул хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулж, битүүмжлэлийг байнга хянаж шалгаж байна.



**Зураг 22. Ажилчдын кемп болон гаалийн хяналтын талбайн гадна хогийн цэг**

# ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Фүжибит” ХХК-ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд гаалийн хяналтын талбайд ажил гүйцэтгэж буй ажилчдын хотхоны эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.



**Зураг 23. Ногоон байгууламж**

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрын 10 %-иас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж зүлэгжүүлэх шаардлага, Газрын тухай хуулийн 56.6 заалтыг хангуулахаар ажилчдын кемпийн гадна талбайд мод тарьж арчилгаа усалгааг тогтмол хийж ажиллаж байна.







**Зураг 24. Модны усалгаа арчилгаа хийж буй нь**



**Зураг 25. Төслийн талбайд байршуулсан гэрэлтүүлэг**







**Зураг 26. Ажилчдын кемпийн явган хүний зам талбай**

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын хэвлий бохирдох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах зорилгоор нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайн гадна, дотор талбайд, менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээт “Талын цэнхэг трейд” ХХК-ийн ажилчдын кемп, оффис, тус талбайгаас нүүрс ачилт буулгалт хийдэг тээврийн компани “Эко глобал ложистикс” ХХК-ийн ажилчдын 40 га кемп, төв кемп, оффисын талбай болон нийтийн эзэмшлийн талбайд бүх нийтийн цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж ажиллаж байна.



**Зураг 27. Бүх нийтийн хог цэвэрлэгээ хийж буй байдал**

## ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлж байх явцад олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагаа түр зогсоож, Ханбогд сумын цагдаа, сумын засаг дарга, соёлын өвийн судалгааны байгууллагад мэдэгдэнэ гэж төлөвлөсөн бөгөөд “Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй болно.

# ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь машин техник, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйл ажиллагааны хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа анхаарч ажиллах шаардлагатай.

## 5.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Байгалийн гамшгийн улмаас ажилчдын эрүүл мэнд, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай бороо орох үед үйл ажиллагааг түр зогсоож ажиллахаар төлөвлөсөн бөгөөд одоогоор үйл ажиллагаа эхлэсэнээс хойш хүчтэй салхи шуурга болон онцгой нөхцөл үүссэн тохиолдолд ачилт буулгалтын үйл ажиллагааг зогсоож ажиллаж байна.

“Фүжибит” ХХК-ийн гаалийн хяналтын талбайд ачилт буулгалт хийдэг нүүрс тээврийн “Эко глобал ложистикс” ХХК болон гаалийн хяналтын талбайд ачилт буулгалтын үйл ажиллагааны менежментийн үйлчилгээ үзүүлдэг “Талын цэнхэг трейд” ХХК-ийн Цагаан хад суурьшлын бүс дэх кемпийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Ханбогд сум дахь Гал түймэр унтраах, аврах 66 дугаар гал түймрийн улсын хяналтын байцаагчаар хянуулан баталгаажуулж мөрдөн ажиллаж байна.






**Зураг 28. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө**

Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын Онцгой байдлын газар хүсэлт гаргаж нийт ажилтанд галын сургалт, гамшгаас хамгаалах сургалт авсан.



**Зураг 29. Онцгой байдлын сургалт зохион байгуулж буй байдал**

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдлээс сэргийлэх төлөвлөгөөний байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, байгалийн гамшиг гарсан тохиолдолд авах арга хэмжээний биелэлтийг хангах зорилгоор Гаалийн хяналтын талбайн ажилчдад Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.



**Зураг 30. Давтан зааварчилгаа**

## 5.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Төслийн талбайд цахилгаан үүсгүүр болон тамхины цог зэргээс гал түймэр гарч болзошгүй бөгөөд гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулж галын хорыг байнга шалгаж, цэнэглүүлж ажиллаж байна.




**Зураг 31. Галын сарай, гал унтраах багаж хэрэгсэл байрлуулсан байдал**

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Онцгой байдлын газраар Галын аюулгүй байдлын дүгнэлтийг “Эко глобал ложистикс” ХХК-ийн  Ажилчдын кемпэд 2024 оны 05-р сарын 27-ны өдрөөс 2026 оны 05-р сарын 27-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар гаргуулсан.



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0015798

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "ЭКО ГЛОБАЛ ЛОЖИСТИК" ХХК

Хаяг: ӨМНӨГОВЬ АЙМАГ, ХАНБОГД СУМ, ЦАГААН ХАД

үйл ажиллагааны чиглэл: "АЖИЛЧДЫН КЕМП"

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал тэргийг байрлуулан ашиглахад зохих дүгнэлтийг олгоно

/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон 2024 он 05 сар 27 өдөр

Хүчинтэй хугацаа: 2026 он 05 сар 27 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

ӨМНӨГОВЬ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

дарга ХУРАНДАА цолтой М.АДЪЯАБААТАР

Дүгнэлт гаргасан:

ӨМНӨГОВЬ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

Гал түймрийн улсын хяналтын байцаагч: АХМАД цолтой Б.НАРАНЦАЦРАЛ

/тэмдэг дарна/

**Зураг 32. Галын аюулгүй байдлын дүгнэлт**

## 5.3. Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Болзошгүй осол, саатал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, барилгын үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлж ажилчдыг ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд өдөр тутам тогтмол хамруулан ажиллаж байна.



**Зураг 33. ХАБЭА-н зааварчилгаа өгч буй байдал**




**Зураг 34. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэл**

Тээврийн хэрэгслийн шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийлгэсэн байх, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанд хэрэглэхээр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, хянаж, бүртгэл хөтлөн ажилладаг.

Ажилчдын эрүүл мэнд хохирохоос урьдчиан сэргийлж, яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг байршуулсан.




**Зураг 35. Анхны тусламжийн хэсэг**

“Эко глобал ложистикс” ХХК-ийн “Гал унтраах шуурхай төлөвлөгөөг Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Ханбогд сум дахь Гал түймэр унтраах, аврах 66 дугаар гал түймрийн улсын хяналтын байцаагчаар хянаж баталгаажуулан ажиллаж байна.



**Зураг 36. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө**

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт ажилчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгож ажиллаж байна.



**Зураг 37. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олгосон байдал**

# ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг, Цагаан хаданд байрлах “Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллаж байна.

“Фүжибит” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Гаалийн хяналтын талбайд орчны тохижилт, барилга байгууламж нэмж байрлуулахдаа дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах, хатуу, шингэн хог хаягдлыг хэт хуримтлуулахгүй байж хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гэрээний хэрэгжилтийг ханган ажиллав.

## 6.1. Энгийн хог хаягдлын менежмент

### *6.1.1. Хатуу хог хаягдал*

“Фүжибит” ХХК-ийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь цаасны хаягдал, хуванцар хаягдал, бусад гэж 3 ангилан цуглуулж, нэгдсэн нэг хогийн цэг дээрх хогийн саванд түр хадгалдаг. Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулж, битүүмжлэлийг байнга хянаж шалгаж байна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэргийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиварын үйлдвэрт тушаахаар зориулалтын түр хадгалах саванд хадгалж, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах арга хэмжээг авч ажиллаж байна.



**Зураг 38. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав**

Энгийн хатуу хог хаягдлыг зайлуулах гэрээг Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулж, гэрээний дагуу ачуулж зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байна. Хог хаягдлын гэрээг тайлангийн хавсралт хэсэгт орууллаа.



**Зураг 39. Ажилчдын кемп болон гаалийн хяналтын талбайн гадна хогийн цэг**

### *6.1.2. Ахуйн шингэн хаягдал*

Ажилчдын кемпийн ахуйн бохир усыг ёмкостонд хуримтлуулан Ханбогд сумын төв рүү гэрээний дагуу хүргүүлэн цэвэрлэх байгууламж руу нийлүүлж байна.



**Зураг 40. Ахуйн бохир шингэн хаягдлын худаг**

Бохир ус соруулах, тээвэрлэх гэрээг “Алаг хайрханы нөмөр” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байна. Энэхүү гэрээ болон бусад дэлгэрэнгүйг хавсралт хэсгээс харна уу.

## 6.2. Аюултай хог хаягдлын менежмент

“Фүжибит” ХХК-ийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний аюултай хог хаягдлын менежментэд тусгаснаар машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан эрх бүхий дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөн хуримтлуулж байна.




**Зураг 41. Эмнэлгийн хог хаягдал**

“Фүжибит” ХХК-тай менежментийн гэрээтэй ажилладаг “Талын цэнхэг трейд” ХХК нь гаалийн хяналтын талбайд ашиглалаг техник хэрэгслийн засвар зэрэг бусад эх үүсвэрээс ялгарах аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх, түр хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагааны гэрээ”-г “Ханбогд вейст менежмент центр” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулахаар стандартын дагуу хуримтлуулан ажиллаж байна.

Ханбогд сум Цагаан хадны суурьшлын бүэд байрлах кемпийн эмнэлгийн хог хаягдал, мөн машин механизмын засварын төвийн үйл ажиллагаанаас үүсэх машин механизмын ангилалд багтах тос, тосолгооны материал, цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах чиглэлээр хамтран ажилладаг.

## ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан мониторингийн цэгүүдэд үндэслэн 2024 оны мониторинг хийх цэг, үзүүлэлтүүдийг дараах байдлаар сонгон авч хэмжилт дээжлэлтүүдийг хийж гүйцэтгэсэн.

**Хүснэгт 2. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил**

| Цэгийн дугаар | Төрөл | Байршил | Солбицол* | |
|---|---|---|---|---|
| | | | X | Y |
| **1** | Агаар | Нүүрс ачилт буулгалтын талбай | $107^0$ 32’ 07.7” | $42^0$ 35’ 09.1” |
| **2** | Хөрс 1 | Нүүрс ачилт буулгалтын талбай | $107^0$ 31’ 57.9” | $42^0$ 35’ 07.0” |
| **3** | Хөрс 2 | Авто зогсоол, зам дагуу | $107^0$ 32’ 13.7” | $42^0$ 35’ 16.4” |
| **4** | Ус 1 | 40 га кемпийн шугамын ус | $107^0$ 28’ 34.78” | $42^0$ 38’ 07.22” |
| **5** | Ус 2 | Төв кемпийн гал тогоо | $107^0$ 32’ 38.25” | $42^0$ 35’ 31.75” |
| **6** | Ус 3 | 40 га кемпийн Ахуйн бохир ус | $107^0$ 28’ 34.78” | $42^0$ 38’ 07.22” |

*Тайлбар: *-Солбицолын тогтолцоо WGS84 UTM Zone48*

Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн нутаг, Цагаан хаданд байрлах Гаалийн хяналтын талбайн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгийн байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 42. Мониторингийн цэгүүдийн байршил**

## 7.1. Агаарын чанарын хяналт, шинжилгээ

### *7.1.1. Судалгааны аргазүй*

#### 7.1.1.1. Хээрийн судалгаа

“Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбай орчмын агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хээрийн судалгааг 2024 оны 6-р сар болон 9-р сард, жилд 2 удаа хийж гүйцэтгэсэн. Энэхүү төслийн талбайн агаарын чанарын мониторинг хийх гадаад орчны 2 цэгт тоос, азотын давхар исэл, хүхэрлэг хий, шуугианы дээжлэлт, хэмжилт хийв. Дээжийг авахдаа “Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384:1984” стандартыг баримталсан. Утааны хийг агаарын хяналт шинжилгээний цэгийн орчмын агаараас 2л/мин хурдтайгаар 20 минутын турш шингээгч гуурсанд соруулсан бол нийт тоосыг DustTack 8530 багажаар, дуу шуугианыг JEIC Type 1015 загварын зөөврийн багажаар тус тус хэмжив.



**Зураг 43. Хээрийн судалгааны багаж**

***Хүхэрлэг хий.*** Төслийн талбай орчмын агаараас 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шигээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлно.

***Азотын давхар исэл.*** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын туршсоруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфаналины хүчилтэй харилцан үйлчилж диазо нэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь α - нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

***Тоос.*** Агаар дахь тоосны агууламжийг DustTrak Monitor II Model 8530 гэх зөөврийн автомат багажаар тодорхойлсон бөгөөд энэ багаж нь агаар дахь PM10, PM2,5, PM1.0 хэмжээтэй

тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг хэмжинэ.

Агаарт агуулагдаж байгаа тоосыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн саринал тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт тулгуурласан.

#### 7.1.1.2. Лабораторийн задлан шинжилгээ

Утааны хийн дээжнүүдэд лабораторийн задлан шинжилгээг MNS 0017-2-5-11:1988 “Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга”, MNS 0017-2-5-12:1988 “Агаар мандал. Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга”-уудыг ашигласан байна.

#### 7.1.1.3. Зураглал

Агаарын мониторингийн цэгийн байршилын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программын тусламжтай хийж гүйцэтгэв.

**Хүснэгт 3. Агаарын чанарын мониторингийн цэг /Гадаад орчин/**

| д.д | Солбицол | | Цэгийн нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| | X | У | | |
| **1** | $107^0$ 32’ 07.7’’ | $42^0$ 35’ 09.1’’ | А-1 | Ачилт буулгалтын талбайд |




**Зураг 44. Агаарын мониторингийн цэг**



**Зураг 45. Агаарын чанарын шинжилгээ хийсэн хэсэг /6 болон 9-р сар/**

### *7.1.2. Судалгааны үр дүн*

“Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд төслийн талбай орчмын агаарын чанарыг тодорхойлох зорилгоор агаарын чанарын шинжилгээ хийсэн болно.

Өмнөговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторит шинжилсэн агаарын чанарын сорилтын 2024 оны 06-р сар болон 09-р сарын үр дүнг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 4. Агаарын шинжилгээний лабораторийн сорилтын дүн**

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | PM2.5 Тоосонцор /20 минут/ | | Нийт тоосны агууламж /TSP/, мг/м$^3$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **“Фүжибит” ХХК, Гаалийн хяналтын талбай** | | | | | | | | |
| **2024 оны 6-р сар** | | | | | | | | |
| **1** | Ачилт буулгалтын талбай | VI/04 | 13:55 | 9 | 74 | 42 | 71 | 125 |
| **2024 оны 09-р сар** | | | | | | | | |
| **1** | Ачилт буулгалтын талбай | IX/14 | 13:00 | 20 | 16 | 43 | 55 | 102 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | | **450** | **200** | **50** | **100** | **500** |

Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээг тогтоосон стандартын үзүүлэлттэй гаалийн хяналтын талбайн гадна агаарын сорилтын дүнг харьцуулахад агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж нь сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит шинжилсэн агаарын чанарын сорилтын дүнг хавсралт хэсэгт оруулав.

## 7.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

### *7.2.1. Судалгааны аргазүй*

#### 7.2.1.1. Хөрсний хээрийн судалгаа

Гаалийн хяналтын талбайн хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2024 оны 5-р сар болон 09-р сард хийж гүйцэтгэсэн. “Фүжибит” ХХК-ийн хөрсний мониторинг хийх нийт 2 цэгээс өнгөн хөрсний буюу 0-10 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдолын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298 : 1990” стандартыг баримталсан.

#### 7.2.1.2. Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжнүүдэд агро-химичи, физик шинж, хүнд зэрэг үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. *Хөрсний агрохимийн шинж* чанарын үзүүлэлтүүдийг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан болно. Үүнд:

- Ялзмаг - Тюриний
- Урвалын орчин (pH) - Потенциометрийн
- $CaCO_3$ карбонат - Кальциметрийн
- Механик бүрэлдэхүүн - Гидрометрийн
- Давсжилт, EC - Потенциометрийн
- Фосфор - Спектро фотометр
- Кали - Дөлт фотометр

Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991” стандартуудыг мөрдлөг болгосон байна.

#### 7.2.1.3. Зураглал

Хөрсний мониторинг цэгийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программ дээр хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг A4 хуудсан дээр 1:6000 масштабтай бэлдсэн.

**Хүснэгт 5. Хөрсний мониторингийн цэгийн солбицол**

| № | Мониторинг цэг | Ерөнхий байршил | Цэгийн солбилцол | |
|---|---|---|---|---|
| | | | Y | X |
| 1 | S1 | Нүүрс ачилт буулгалтын талбай | $107^0$ 31’ 57.9” | $42^0$ 35’ 07.0” |
| 2 | S2 | Орц гарцны хэсэгт тээврийн зам дагуу | $107^0$ 32’ 13.7” | $42^0$ 35’ 16.4” |




**Зураг 46. Хөрсний мониторингийн цэгийн байршил**

## *7.2.2. Судалгааны үр дүн*

“Фүжибит” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, талбайн хөрсөн бүрхэвчийн шинж чанарыг тодорхойлох зорилгоор төслийн талбайгаас өнгөн хөрсний дээжлэлт хийж хөрсний химийн үндсэн шинж, хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсний хүнд металл тодорхойлох шинжилгээг Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шижилгээний лабораторит шинжлүүлсэн болно.

“Фүжибит” ХХК-ийн төслийн талбайгаас авсан хөрсний дээжлэлтүүд хийсэн хэсгийг дараах зургаар харуууллаа.



**Зураг 47. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Ачилт буулгалтын талбайд 6 болон 9-р сар/**




**Зураг 48. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Авто зогсоолын ойролцоо 6 болон 9-р сар/**

***Хөрсний химийн үндсэн шинж.*** Гаалийн хяналтын талбайгаас авсан өнгөн хөрсний химийн үндсэн шинжийг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 6. Хөрсний химийн үндсэн шинж**

| № | Сорьц авсан цэгийн нэр | Орчин-pH | Чийг, % | Сульфат ($SO_4$) | Нитрат ($NO_3$) мг/кг | Аммони ($NH_4$-N) мг/кг | Ялзмаг, % | Фосфор ($P_2O_5$) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2024 оны 06-р сар** | | | | | | | | |
| **1** | Ачилт буулгалтын талбай | 8.93 | 1.23 | 2494.9 | 91.1 | 2.43 | 1.67 | 12.1 |
| **2** | Авто машины зогсоол | 8.94 | 0.65 | 699.8 | 272.2 | 15.7 | 1.87 | 20.2 |
| **2024 оны 09-р сар** | | | | | | | | |
| **1** | Ачилт буулгалтын талбай | 9.60 | 0.17 | 661.6 | 1.08 | 16.7 | 0.71 | 0.39 |

Нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайд хийсэн хөрсний дээжлэлт нь сул хүчиллэгээс саармаг урвалын орчинтой, ялзмагийн агууламжаар бага зэрэг, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг байна.

Хөрсний үржил шимт чанар буурах, хөрсний гадарга байгалийн төрхөө алдах байдлыг хөрсний эвдрэл гэж үздэг бөгөөд тус төслийн талбайн хэмжээнд хийсэн хээрийн судалгааны явцад элэгдэл эвдрэлийн ул мөр ажиглагдсан бөгөөд талбай нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байна.

***Хөрсний хүнд металл.*** Хөрсөн дэх хүнд металлын агууламж өнгөн хэсэгтээ (0-10 см) хар тугалга, кадми, мөнгөн ус, стронци, хром, зэс, цайр шинжлүүлсэн сорилтын дүнд “Хөрсний

чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019) стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт гараагүй буюу бохирдолгүй байна. Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит шинжлүүлсэн Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 7. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд**

| Д/д | Гүн | Cr | Pb | Cd | Zn | Cu | Hg | Sr |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| S1 Авто машины зогсоол | 10 см | 2.6 | 6.6 | 1.1 | <0.5 | 28 | <0.005 | 225 |
| **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019** | | | | | | | | |
| **Шаварлаг хөрс** | | **150** | **100** | **3** | **300** | **100** | **2** | **800** |

Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүнг хавсралт хэсэгт оруулсан болно.

## 7.3. Усны чанарын хяналт шинжилгээ

### *7.3.1. Судалгааны аргазүй*

#### 7.3.1.1. Газар дээрх хэмжилт дээжлэлт

“Фүжибит” ХХК нь ажилчдын ундны зориулалтын усны хэрэглээг савласан цэвэр усаар хангадаг, ахуйн хэрэглээг гүний худгаас зөөврөөр хангаж байгаа бөгөөд нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, унд-ахуйн усны чанарыг тодорхойлох зорилгоор ахуйн хэрэглээний уснаас дээж авч усны химийн ерөнхий шинжилгээг Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шижилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн болно.

Гаалийн хяналтын талбай төслийн ажилчдын кемп болон гал тогооны дээжлэлт хийсэн байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 49. Усны мониторингийн цэгийн байршил**



**Зураг 50. Усны дээжлэлт хийсэн хэсэг /2024 оны 06 болон 09-р сар/**

**Хүснэгт 8. Усны мониторингийн цэгүүдийн координат**

| № | Дээжний төрөл, нэр | Солбицол | |
|---|---|---|---|
| | | Уртраг | Өргөрөг |
| **1** | 40 га кемпийн шугамын ус | $107^0$ 28’ 34.78” | $42^0$ 38’ 07.22” |
| **2** | Төв кемпийн гал тогоо | $107^0$ 32’ 38.25” | $42^0$ 35’ 31.75” |
| **3** | 40 га кемпийн Ахуйн бохир ус | $107^0$ 28’ 34.78” | $42^0$ 38’ 07.22” |

### 7.3.1.2. Усны чанарын шинжилгээ

Төслийн ахуйн ус, ахйун бохир ус, ундand ашигладаг цэвэр усны химийн ерөнхий үзүүлэлтүүдийг Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн болно.

Усны шинжилгээний лаборатори нь биоген элементүүд болох аммони ($NH_4$), нитрит ($NO_2$), нитрат ($NO_3$), исэлдэх чанар (ПИЧ), гол ионууд болох сульфат ($SO_4$), төмөр (Fe), ерөнхий хатуулаг, кальци ($Ca^{2+}$), магни ($Mg^{2+}$) зэргийн агууламжийг тодорхойлдог ба усны шинжилгээ хийсэн аргачлалыг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 9. Усны шинжилгээний аргачлал**

| № | Шинжилсэн үзүүлэлтүүд | Шинжилгээний аргачлал |
|---|---|---|
| **1** | Ерөнхий хатуулаг | Комплексометрийн арга |
| **2** | Хлорид | Арганометрийн арга |
| **3** | Кальци | Комплексометрийн арга |
| **4** | Магни | Тооцооны арга |
| **5** | Сульфат | Турбидиметрийн арга |
| **6** | Төмөр | Колориметрийн арга |
| **7** | Аммони, нитрат, нитрит | Хараaны колометрийн арга |

**Хүснэгт 10. Шинжлэх аргын стандарт**

| № | Үзүүлэлт | Шинжлэх аргын стандарт |
|---|---|---|
| 1 | Усны орчин pH | MNS ISO 10523:2001 |
| 2 | Хатуулаг | MNS 1097:1970 |
| 3 | Кальци /Ca | MNS 1097:1970 |
| 4 | Магни /Mg | MNS 1097:1970 |
| 5 | Хлор /Cl | MNS 4424:2005 |
| 6 | Нитрат /$NO_3$ | MNS 6334:2020 |
| 7 | Сульфат /$SO_4$ | MNS 6271:2011 |
| 8 | Умбуур бодис ЖБ | MNS 6836:2020 |
| 9 | ЦЧД TDS | MNS ISO 7888:1999 |
| 10 | Аммони /$NH_4$ | MNS ISO 7150-1:2006 |
| 11 | Нитрит /$NO_2$ | MNS 6779:2019 |
| 12 | Фторид /F | MNS 6272:2011 |
| 13 | Төмөр /Fe | MNS 1097:1970 |
| 14 | Фосфор /$PO_4$ | MNS ISO 6878:2001 |

Унд ахуйн усны шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулж дүгнэлт гаргалаа. Энэхүү стандартын зорилго нь хүн амын ундны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн болон чанар, аюулгүй байдлын шаардлага хангуулахад оршино. Харин 40 га кемпийн ахуйн бохир усыг Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандарттай харьцуулсан болно.

### *7.3.2. Судалгааны үр дүн*

Гаалийн хяналтын талбайн ажилчдын унд ахуйн хэрэглээний усны чанарыг тодорхойлох зорилгоор хийсэн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн усны химийн ерөнхий шинжилгээний үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харуулаа.

**Хүснэгт 11. Усны химийн шинжилгээний үзүүлэлтүүд**

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | MNS 0900:2018 | Гал тогоо | Шугамын ус | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024.06 | 2024.09 |
| 1 | Усны орчин pH | | **6.5-8.5** | 8.40 | **9.20** | 8.50 |
| 2 | Хатуулаг | мг-экв/л | **<7.0** | 0.54 | **9.08** | 3.60 |
| 3 | Кальци /Ca | мг/л | **<100.0** | 8.62 | 96.1 | 53.9 |
| 4 | Магни /Mg | мг/л | **<30.0** | 5.23 | **52.0** | 11.1 |
| 5 | Хлор /Cl | мг/л | **<350.0** | 29.6 | 138.6 | 98.2 |
| 6 | Нитрат /$NO_3$ | мг/л | **<50.0** | 0.51 | 2.61 | 11.3 |
| 7 | Сульфат /$SO_4$ | мг/л | **<500.0** | 8.79 | 90.3 | 331.3 |
| 8 | Умбуур бодис ЖБ | мг/л | **Илрэхгүй** | Илр | Илр | 24 |
| 9 | ЦЧД TDS | 1 мСм/м | **1.0** | 1704 | **1098** | **2032** |
| 10 | Аммони /$NH_4$ | мг/л | **1.5** | 0.015 | 0.28 | Илр |
| 11 | Нитрит /$NO_2$ | мг/л | **1.0** | 0.005 | 0.035 | 0.001 |
| 12 | Фторид /F | мг/л | **0.7-1.5** | 0.09 | **2.58** | **3.2** |
| 13 | Төмөр /Fe | мг/л | **0.3** | Илр | 0.052 | Илр |
| 14 | Фосфор /$PO_4$ | мг/л | **3.5** | Илр | 1.13 | 0.006 |

Ажилчдын төв кемпийн гал тогооноос авсан ундны усны шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Харин 40 га кемпийн шугамын усны 06-р сард шинжлүүлсэн усны pH, хатуулаг, магни, цахилгаан дамжуулах чадвар, фторид нь уг стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлттэй, 09-р сард шинжлүүлсэн шугамын усны цахилгаан дамжуулах чадвар, фторидын үзүүлэлт нь стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна. Шугамын усны бусад шинжилсэн үзүүлэлтүүд нь стандартын шаардлагыг хангаж байна. Лабораторийн шинжилгээний үр дүнг хавсралт хэсэгт оруулсан болно.

**Хүснэгт 12. Ахуйн бохир усны химийн үзүүлэлтүүд**

| д/д | Үзүүлэлт | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Усны $t^0$ | Усны орчин pH | ЖБ (мг/л) | Нийт азот (мг/л) | $NH_4$ (мг/л) | $БХХ_5$ (мгО/л) | TP (мг/л) | $SO_4$ (мг/л) | Cl (мг/л) |
| **1** | **MNS 6561:2015** | **30** | **6.0-9.0** | **400** | **30** | **15** | **400** | **5** | **700** | **1000** |
| **2** | Хаягдал ус | 20.2 | 9.20 | 58 | 0.33 | 40.2 | 370 | 4.23 | 280.8 | 274.7 |

“Фүжибит” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайн ажилчдын байрладаг 40 га кемпийн ахуйн бохир усны орчин буюу pH үзүүлэлт нь Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015 стандартын бага зэрэг давсан, аммонийн азотын үзүүлэлт нь уг стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг давсан үзүүлэлттэй, бусад үзүүлэлт нь энэхүү стандартын шаардлагыг хангаж байна. Итгэмжлэгдснэн лабораторийн шинжилгээний үр дүнг хавсралт хэсэгт оруулсан болно.

## НАЙМ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн хариуцлага хүлээх бөгөөд байгаль орчныг хамгаалахад төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажилласан болно.

БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулж мөрдөн ажилласан.



БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА — Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ФҮЖИБИТ" ХХК ЗАХИРАЛ — WANG CHANG QING

"ФҮЖИБИТ" ХХК НИЙ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМАНД ХЭРЭГЖИХ "ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ" БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6175724

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН — ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
"ФҮЖИБИТ" ХХК БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Д.ДАВААСҮРЭН

2024 ОН

**Зураг 51. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байна.

ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулж ажилладаг.

Гэнэтийн осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтын ажлыг зохион байгуулж ажилладаг бөгөөд дэлгэрэнгүйг осол эрсдлээс урьдчилан сэргийлэх бүлэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

“Талын цэнхэг трейд” ХХК-ийн ХАБЭА-н сургалтыг цахимаар өгдөг бөгөөд сургалтын мэдээллийг дараах зургаар харуууллаа.




**Зураг 52. ХАБЭА-н сургалтын цахим систем**





Зураг 53. Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийсэн байдал

# ЕС. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Фүжибит” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Гаалийн хяналтын талбайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тусгасан онцгойлон анхаарах зүйлс болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цаг тухай бүрд нь даган мөрдөх ажлын хүрээнд 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг Өмнөговь аймгийн байгаль орчны газарт 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлийн тайланг хүргүүлж байна.

**Хүснэгт 13. 2024 онд зарцуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал**

| № | Гүйцэтгэсэн ажлы нэр | Зардал, төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний зардал | 1,112,284,701 |
| 2 | Орчны тохижилт, Ногоон байгууламж байгуулсан зардал | 116,929,181.82 |
| 3 | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал | 2000,000 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал | 3,500,000 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | 1,392,000 |
| 6 | Удирдлага зохион байгуулалтын зардал | 1000,000 |
| **Нийт зардал** | | **124,821,181.82** |

“Фүжибит” ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад нийт 124,821,181.82 (нэг зуун хорин дөрвөн сая найман зуун хорин нэгэн мянга нэг зуун наян нэгэн)  төгрөгийг зарцуулсан байна.

# ХАВСРАЛТ

- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Газрын кадастрын зураг
- Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ
- Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ
- Газрын гэрээ дүгнэсэн акт
- Гаалийн хяналтын бүс тогтоосон тушаал
- Аюултай хог хаягдлын гэрээ
- Хог хаягдлын гэрээ
- Ахуйн бохир соруулах гэрээ
- Агаарын шинжилгээний сорилтын үр дүн
- Хөрсний шинжилгээний үр дүн
- Усны шинжилгээний үр дүн

МОНГОЛ УЛС

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000298102

2017.04.20
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011861255
/ Хувийн хэргийн дугаар /

6175724
/ Регистрийн дугаар /

Фүжибит — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2017.04.18 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 7210 | Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх |
| 49230 | Авто машинаар ачаа тээвэрлэх |
| 45400 | Авто машины засвар, үйлчилгээ |
| 45300 | Авто машины сэлбэг, эд ангийн худалдаа |
| 45209 | Авто машины дугуй засвар |
| 45100 | Авто машины худалдаа |
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
| 52290 | Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа |

| Хугацаагүй | 2 | 340,500.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Өмнөговь, Ханбогд, 4-р баг, Баян, Шар дов, 17-2 тоот, Утас1: 88101808, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Ш.ОЧИРСҮРЭН
/тэмдэг/ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2024 он 02 сар 19 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Wang овогтой Chang Qing-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | 2024.02.19 | Ш.Очирсүрэн |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | 2024.02.19 | Ш.Очирсүрэн |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000298102

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/160 Улаанбаатар хот

“Фүжибит” ХХК-ийн гаалийн хяналтын бүс тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсэг, $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.9, $271^1$.1.17 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын 2019 оны А/294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам” –ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 04/06 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Фүжибит” ХХК -ийн Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан, 5 дугаар баг, Цагаан хад суурьшлын бүсэд байрлах, 4601009717 нэгж талбарын дугаартай 13.6га талбайг уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн ачих, буулгах, экспортлох зориулалт бүхий гаалийн хяналтын бүсээр 3 жилийн хугацаагаар тогтоосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ын 4 дүгээр хавсралтад “Фүжибит - 314061“ гэж нэмсүгэй.

3. “Фүжибит” ХХК-тай гэрээ байгуулан, Гаалийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Гашуунсухайт дахь гаалийн газар /Л.Ганбаяр/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, шалгалтын газар /Б.Даваасүрэн/-т, Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА Б.АСРАЛТ

1439501 2358

## ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ НЬ ГАЗАРТ БЭХЭЛСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар:
Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн овог, нэр: **"ФҮЖИБИТ" ХХК**
Хаяг: Өмнөговь аймаг, Ханбогд сум, 5-р баг Хайрхан, Цагаан хад

Регистрийн дугаар: **6175724**




Зургийн масштаб 1:5 000 (1 сантиметрт 50 метр багтана)

Солбицлын систем: WGS84 UTM-48n

| Нэгж талбар: Хашаа | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дугаар | X | Y | Өндөр | Урт | Цэгүүд |
| 1 | 4717748.612 | 707784.991 | 1009.355 | 201.52 | 1-2 |
| 2 | 4717921.973 | 707682.242 | 1007.565 | 126.02 | 2-3 |
| 3 | 4717991.682 | 707787.226 | 1006.698 | 497.21 | 3-4 |
| 4 | 4718267.327 | 708201.030 | 1005.348 | 233.17 | 4-5 |
| 5 | 4718070.337 | 708325.789 | 1003.858 | 629.26 | 5-1 |

**Талбайн хэмжээ:** 136000.0 **квадрат метр**

Хэмжилт үйлдсэн:
Огноо: 2020-08-10
Байгууллагын нэр: "Гурван Хорол" ХХК
Хэмжигчийн нэр: .................................... /Б.Уганхүү/
Хянасан:
Огноо: 2020-08-10
Байгууллагын нэр: "Гурван Хорол" ХХК
Хэмжигчийн нэр: .................................... /Б.Отгонтуул/

Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбицолжуулсан үндэслэлийн цэг:

| | | | | |
|---|---|---|---|---|
| Цэгийн солбицол 1: | X=4717593.539 | Y=714107.976 | H=1116.300 | Триангуляци |
| Цэгийн солбицол 2: | X= | Y= | H= | |

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000009882

Фүжибит ХХК / 6175724 /-д
*(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Ханбогд сумын Засаг даргын -ын 20 20 оны 08 сарын 07 өдрийн А/225 тоот
*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Өмноговь Ханбогд Хайрхан-5
*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Цагаан хад ____ хаягт
*(гудамжны нэр)* *(хашааны дугаар/ тоот)*

байрлах, нэгж талбарын 4601009717 дугаар бүхий 13.6 га м.кв /га/ газрыг

Гаалийн хяналтын талбай зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-1112000150

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН

ТАМГА / ТЭМДЭГ

М.Оюун / М.Оюун-Эрдэнэ /
*(гарын үсэг)* *(нэр)*

20 20 оны 10 сарын 01 өдөр

MNSPC

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тамга |
| 1 | | | |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Нэгж талбарын дугаар: **4601009717**
Улсын бүртгэлийн дугаар: **Э-1112000150**
Гэрчилгээний дугаар: **000009882**

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

**2020** оны **10** сарын **2** өдөр **№ 04631-2020/00060** ***Өмнөговь аймаг Ханбогд сум***

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, **Өмнөговь** аймаг **Ханбогд** сумын Засаг даргын **2020** оны **07** сарын **10** -ны өдрийн **А/225** тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, **Өмнөговь** аймаг **Ханбогд** сум Газрын албаны мэргэжилтэн **Мөнх-Очир** овогтой **Оюун-Эрдэнэ,** газар эзэмшигчийг төлөөлж **Фужибит ХХК-ны овогтой** нар энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ **136000 м2**

Үүнээс:

| Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт | Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ | Газар эзэмших хугацаа |
|---|---|---|
| Гаалийн хяналтын талбай | 9.5 | 3 жил |
| Ногоон байгууламж | 4.1 | |

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирлаар ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

**Гурав. Газар эзэмшигчийн эрх**

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4.Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /*Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах*/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь

1

хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

**Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг**

4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ *5 жилд нэг удаа хийлгэнэ./*;

4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх

4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах

4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
4.19 Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх
4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

**Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг**

5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;

5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараах шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх
б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх
в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах
г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

2

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

**Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт**

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: “**хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...**” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

**“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй”** гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

**Долоо. Бусад зүйл**

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

3

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар эзэмшүүлэгч;
Өмнөговь аймгийн Ханбогд сум
Засаг даргын Тамгын газар 105 дугаар өрөө

Газар эзэмшигч: **Фүжибит ХХК** овогтой
Газрын байршил: **Өмнөговь Ханбогд 5-р баг Цагаан хад**
Газар эзэмшигчийн хаяг: **Улаанбаатар Хан-Уул 15-р хороо**
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/6175724/**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:

Ханбогд сумын Засаг дарга
**Ш.Эрдэнэжаргал** /………………………/тамга

Сумын Газрын даамал
**М.Оюун-Эрдэнэ**
гарын үсэг /……………………………/

Газар эзэмшигчийг төлөөлж:

**Фүжибит ХХК-ны Захирал ажилтай Нямдорж овогтой Отгонболд**

/гарын үсэг/…………………/тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг **4601009717** дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

4

"Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын
3 дугаар хавсралт

**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ**
**ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭСЭН АКТ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар:1

**ФУЖИБИТ ХХК-д**

*/иргэн, хуулийн этгээдийн нэр/*

Сумын Засаг даргын **2020** оны **08** дугээр сарын **07**-ний өдрийн **А/225** тоот

*/шийдвэр гаргагч/*

шийдвэрийг үндэслэн Өмнөговь Ханбогд Хайрхан

*/аймаг, нийслэл/ /сум, дүүрэг/ /баг, хороо/*

**Цагаан хад** хаягт

*/гудамжны нэр/ /хашааны дугаар/тоот/*

байрлах, нэгж талбарын **4601009717** дугаар бүхий **136000 м.кв** /га/ газрыг **Гаалийн хяналтын талбай**

*/нэгж талбарын дугаар/ /талбайн хэмжээ/ /газар ашиглалтын зориулалт/*

зориулалтаар

**15** жилийн хугацаатайгаар 04631-2020/00060 дугаар бүхий гэрээ

*/гэрээний дугаар/*

байгуулан эзэмшиж/ашиглаж буй газрын гэрээний үүргийн биелэлтийг дараах байдлаар дүгнэв.

1. Газрын төлбөр төлсөн эсэх

| Төлбөрийн утга | Талбайн хэмжээ /м.кв/ | Төлөх | Төлсөн |
|---|---|---|---|
| 2024 оны 1-р улиралын ногдуулалт | 136000 | 680000 | 680000 |
| 2024 оны 2-р улиралын ногдуулалт | 136000 | 680000 | 680000 |
| 2024 оны 3-р улиралын ногдуулалт | 136000 | 680000 | 680000 |
| 2024 оны 4-р улиралын ногдуулалт | 136000 | 680000 | 680000 |

2. Газрыг гэрээнд заасан газар ашиглалтын зориулалтын дагуу эзэмшиж/ ашиглаж буй эсэх — Тийм ☑ Үгүй ☐

*/Үгүй гэсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

3. Эргэлтийн цэг тэмдэгтээр баталгаажуулсан талбайгаар хашаа барьсан эсэх — Тийм ☑ Үгүй ☐

*/Үгүй гэсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

4. Шийдвэрээр олгогдсон талбайн хэмжээгээр газар эзэмшиж/ашиглаж буй эсэх — Тийм ☑ Үгүй ☐

*/Үгүй эсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

5. Нийтийн эзэмшлийн зам талбай, орц гарцыг чөлөөтэй байлгаж буй эсэх — Тийм ☑ Үгүй ☐

*/Үгүй эсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

6. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй эсэх — Тийм ☑ Үгүй ☐

*/Үгүй эсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

7. Өөрийн эзэмшлийн газар болон орчны 50 хүртэлх метр нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламжийг хамгаалж, тохижилт хийсэн эсэх — Тийм ☐ Үгүй ☑

*Ногоон байгууламжийн ажил хийгдээгүй байна.*

*/Үгүй эсэн сонголтыг хийсэн бол тайлбар бичих/*

8. Бусад

Гэрээний үүргийг биелүүлсэн эсэх талаар гаргасан дүгнэлт:

**Гэрээнд заасан үүрэг биелүүлж байгаа.**

**Цаашид гэрээний үүргийг жил бүр дүгнүүлж байх, Ногоон байгууламж бий болгох ажлыг шуурхай зохион байгуулах.**

| ГЭРЭЭ ДҮГНЭСЭН: | ХЯНАСАН: |
|---|---|
| Ханбогд сумын ЗДТГ | Ханбогд сумын ЗДТГ |
| /Байгууллагын нэр/ | /Байгууллагын нэр/ |
| Газрын даамал | Сумын Засаг дарга |
| /Албан тушаал/ | /Албан тушаал/ |
| /Гарын үсэг/ | /Гарын үсэг/ |

КИА0001 9051007

*Хог тээвэрлэлтийн гэрээ*
*Ханбогд хот тохижолт ОНӨААТҮГ – Эко глобал ложистикс ХХК*

## ХОГ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2024 оны 04 дүгээр
сарын 01-ний өдөр № KHB-Eco20240301 Ханбогд сум

Энэхүү Хог тээвэрлэлтийн гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг үндэслэн,
Нэг талаас **“ХАНБОГД ХОТ ТОХИЖОЛТ” ОНӨААТҮГазар** түүнийг төлөөлөн захирал Догь овогтой **ЭРХЭМБААТАР** /цаашид “Гүйцэтгэгч”гэх/,
Нөгөө талаас **“ЭКО ГЛОБАЛ ЛОЖИСТИКС” ХХК,** болон Захиалагчийн үйлчилгээ авах байршилд байрлах **“Алтан нууц” ХХК, “Дэлгэрэх цагаан овоо” ХХК, “Аранзал алаг” ХХК, “Шанхын хэц” ХХК, “BB транс” ХХК, “Цэций гуа” ХХК, “Хан сахиус” ХХК,** мөн Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад суурьшлын бүсэд байрлах “Гаалийн хяналтын талбай” төсөл хэрэгжүүлж буй **“Фүжибит” ХХК, “Винтрак” ХХК,** түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал **Т.ХАЛИУНАА** /цаашид “Захиалагч тал” гэх/ нар үндэслэн дор дурьдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагч талын захиалгын дагуу энэхүү гэрээний 1.2-т заасан байршлаас хог хаягдлыг ачиж тээвэрлэх, хогийн цэгт хаях /цаашид “Ажил” гэх/, Захиалагч нь уг үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан нөхцлөөр төлөх, талуудын харилцан хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулна.
1.2. Захиалагчийн үйлчилгээ авах байршил: Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад суурьшлын бүс, 40 га кемп, авто зогсоолын талбай болон Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад суурьшлын бүсэд байрлах “Гаалийн хяналтын талбай”
1.3. Талууд гэрээний хэрэгжилтийн явцад харилцан биенээ хүндэтгэн, хамтран ажиллах зарчимтай байх бөгөөд, Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн Аюулгүй байдлын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Тээврийн тухай хууль болон захиалгат ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандарт норм дүрмийг мөрдлөг болгоно.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Гэрээний хугацаа 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 1 /нэг/ жил хүчинтэй.
2.2 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход болон гэрээг цуцлахад Талуудын гэрээнээс үүдэлтэй гомдлын шаардлага гаргах эрх, үүргийн гүйцэтгэлийг хангах үүргээс бусад эрх, үүрэг дуусгавар болно.
2.4 Гэрээний хугацаанд Талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран Гэрээ нь хүчин төгөлдөр хэвээр байна.

### Гурав. Захиалагчийн эрх үүрэг

1

*Хог тээвэрлэлтийн гэрээ*
*Ханбогд хот тохижолт ОНӨААТҮГ – Эко глобал ложистикс ХХК*

Захиалагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
3.1. Хог тээвэрлэгч байгууллагын хог ачиж, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
3.2. Төлбөрийг жилд 2 удаа хуваах төлөх бөгөөд гэрээ байгуулахад 6 сарын төлбөрийг урьдчилан төлсөнөөр гэрээ баталгаажна.
3.3. Захиалагч нь төлбөрийг төлсөнөөр гүйцэтгэгч хог хаягдалыг тээвэрлэнэ.
3.4. Захиалагч нь хогийг ил задгай болон ухсан нүхэнд асгахгүй ба зориулалтын хуванцар сав, поошиг зэрэгт хийсэн байна. Хогийг ухсан нүхэнд хийхийг хориглоно.
3.5. Ажлыг чанарын өндөр түвшинд, бүрэн гүйцэт, хугацаанд нь гүйцэтгэхийг Гүйцэтгэгчээс шаардах, ажилд байгаа дутагдал, алдаа, бүрэн бус байдлаас үүдэн учирсан хохирол, зардлыг нөхөн төлүүлэхээр Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
3.5. Хууль тогтоомжинд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

Гүйцэтгэгч нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
4.1.Захиалагч байгууллагын хог хаягдлыг **сард хоёр удаа тээвэрлэх;**
4.2. Тээвэрлэсэн хог хаягдлыг төвлөрсөн цэгт тээвэрлэж, хогийн төвлөрсөн цэгийн дотоод журмыг чанд сахих;
4.3. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, машин техник эвдэрсэн тохиолдолд хог ачиж цуглуулах хуваарийг алдагдуулахгүй байлгах зорилгоор сэлгэн ажиллуулах машин техникийн бэлэн байдлыг хангах;
4.4. "Хог хаягдлын талбайн хураамж болон үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох тухай" тогтоолд заасан үнийн тарифаар үйлчлэх
4.5. Гүйцэтгэгч нь өөрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ХАБЭА-ны ажилтантай байх, үйл ажиллагаандаа, ХАБЭА-н дүрэм журам, Аюулгүй ажиллагааг чанд мөрдөн, Галын аюулаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Гүйцэтгэгчийн ажилтнууд нь Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа баримтлах дүрэм журам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг чанд мөрдөж ажиллах, аюултай, осолтой байж болзошгүй тоног төхөөрөмж, хэрэгслүүдтэй харьцах шаардлага үүссэн тохиолдолд тухайн тоног төхөөрөмж, хэрэгслүүдтэй харьцаг мэргэжлийн ажилтны зааварчилгаар мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд тийнхүү мөрдөөгүйн улмаас үүссэн хариуцлагыг Гүйцэтгэгч, түүний ажилтан өөрөө хариуцна.
4.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа талбайн бусад хэсэгт хохирол учруулахгүй байх үүрэгтэй бөгөөд Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад Захиалагч болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол уг хохирлыг бүрэн хариуцна.
4.5. Хууль тогтоомжинд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Тав. Төлбөр тооцоо**

5.1. Үйлчилгээний төлбөр: 2 /хоёр/ ачилт буулгалтын хөлс болон шатахуун орсон үнэ 1/нэг/ сарын **330,000 ₮** */гурван зуун гучин мянган/* төгрөг байх бөгөөд НӨАТ орсон дүн болно.
5.2. Төлбөр төлөх нөхцөл: Захиалагч нь үйлчилгээний төлбөрийг 6 /зургаан/ сараар тооцон төлөх бөгөөд, 6 сарын төлбөр болох 1.980.000 ₮ */нэг сая есөн зуун наян мянган/* төгрөгийг Гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг хүлээн авмагц, Гүйцэтгэгч талын **Төрийн банк**ны

2

**Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ** нэртэй **211000143144** тоот төгрөгийн дансанд шилжүүлж байна.

**Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс**

6.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй, биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын 3 хоног дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

6.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн 1 сараас дээш хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн давтагдашгүй хүчин зүйлс гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зорилгоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

**Долоо. Бусад**

7.1. Энэхүү гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

7.2. Гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэн, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

7.3. Гэрээний хугацаа нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.5. Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан этгээдийг тухайн талаа төлөөлөх бүрэн эрхтэй хэмээн үзэх бөгөөд төлөөлөх эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулснаас үүдэн гарах аливаа эрсдэл, хариуцлагыг тухайн төлөөлүүлсэн тал бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Гүйцэтгэгч талыг төлөөлж: | Захиалагч талыг төлөөлж: |
|---|---|
| "Ханбогд хот тохижилт " ОНӨААТҮГазрын захирал | "Эко глобал ложистикс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал |
| ..........Д.Эрхэмбаатар / | ..............Т.Халиунаа |
| Утас: 88115997 | Утас: 88101808 |

3

## БОХИР УС СОРУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2024.04.01 № ECO/AKHN-20240401 Улаанбаатар хот

Энэхүү “Бохир ус соруулах, тээвэрлэх гэрээ”/Цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын 343-358 дугаар заалтууд болон Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн

нэг талаас: хангагч товийг төлөөлж **“АЛАГ ХАЙРХАНЫ НӨМӨР ХХК”** /РД:**3653994**/ (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж захирал Н.Бужинлхам.

нөгөө талаас **“ЭКО ГЛОБАЛ ЛОЖИСТИКС” ХХК** /РД:**3637832** (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж захирал Т.Халиунаа нар /цаашид хамтад нь Талууд гэх/ нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн заасан байршилаас бохир усыг соруулах, тээвэрлэх, Захиалагч нь авсан үйлчилгээнийхээ төлбөрийг төлөх, эдгээртэй холбоотой талуудын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулна.

1.2. Гүйцэтгэгч нь бохир соруулах өөрийн тээврийн хэрэгсэлтэй байх бөгөөд орон нутгийн бохир ус цэвэрлэх байгууламжтай бохир хийх хамтран ажиллах гэрээтэй байна.

1.3. Талууд нь өөр, өөрийн эзэмшилд байгаа бохир усны шугам хоолой, худаг, ариутгал халдваргүйжүүлэлт, ашиглалт хамгаалалтад хяналт тавина.

1.4. Захиалагчийн бохир ус соруулах байршил: Өмнөговь аймаг, Ханбогд сум, 40 га, Төв кемп

1.5. Талууд гэрээний хэрэгжилтийн явцад харилцан биенээ хүндэтгэн, хамтран ажиллах зарчимтай байх бөгөөд, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бохир ус соруулахтай холбоотой стандарт, норм дүрэм, Хөдөлмөрийн Аюулгүй байдлын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, бохир ус тээвэрлэлттэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.6. Гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Гэрээний хугацаа: Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хуанлийн 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй үйлчилнэ.

2.2. Гэрээний хугацаа дуусгавар болоход болон гэрээг цуцлахад Талуудын гэрээнээс үүдэлтэй гомдлын шаардлага гаргах эрх, үүргийн гүйцэтгэлийг хангах үүргээс бусад эрх, үүрэг дуусгавар болно.

2.3. Гэрээний хугацаанд Талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран Гэрээ нь хүчин төгөлдөр хэвээр байна.

2.4. Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох эрхтэй байна.

2.5. **Ажлын хамрах хүрээ:** Гүйцэтгэгч нь Гэрээний Хавсралтад заасан Ажлын даалгавар, төсөвт өртөг, Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу Ажлыг гүйцэтгэнэ. Захиалагч өөрийн шаардлагаар Ажлын даалгавар, ажил гүйцэтгэх хуваарь болон бусад баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөлд Талууд Гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулна. Талуудын зүгээс бичгээр баталгаажуулаагүй Ажилтай холбоотой аливаа төлбөр, зардлыг Захиалагч хариуцахгүй.

2.6. **Чанар:** Гүйцэтгэгч нь Ажлыг Гэрээнд заасан шаардлагын дагуу өөрийн боловсон хүчин, багаж хэрэгслийг ашиглан мэргэжлийн өндөр түвшинд, холбогдох хууль тогтоомж, дүрэм



*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.*

журам, МУ-ын Төмөр замын стандартад нийцүүлэн доголдолгүй, аюулгүй байдлын шаардлага хангасан байдлаар гүйцэтгэнэ.

2.7. **Гомдлын шаардлага гаргах хугацаа** (Баталгаат хугацаа): Талууд засварын “Ажил хүлээлцэх акт”-д гарын үсэг зурсан өдрөөс хойш эхлэх ба **баталгаат хугацаа хуанлийн 1 /нэг/ сар** байх бөгөөд, тус хугацаанд Ажлын гүйцэтгэлд ямарваа нэгэн доголдол илэрвэл Захиалагч гомдлын шаардлага гаргаж болно. Гүйцэтгэгч нь гомдлын шаардлага гаргах хугацаанд гарсан аливаа доголдлыг ажлын 5 (тав) хоногт арилгах ба хэвийн ажиллагаанд оруулна.

**Гурав. Төлбөр**

3.1. Гүйцэтгэгчийн хэрэглээний бохир ус соруулах машин 15 тонн-ын багтаамжтай, Цагаан хадны суурьшлын бүсээс Ханбогд сумын төвд байрлах цэвэрлэх байгууламжид тээвэрлэн буулгахтай холбогдон гарах зардал нь 1 тонн бохир ус тутамд НӨАТ орсон дүнгээр 50,000 /тавин мянган/ төгрөгөөр тооцон төлнө.

3.2. Гүйцэтгэгч нь сар бүрийн 30-наар тасалбар болгон Захиалагчийн кемп менежертэй тооцоо нийлж, төлбөрийн нэхэмжлэх болон цахим төлбөрийн баримтыг өгөх ба Захиалагч нь сар бүрийн 10-ны дотор багтаан төлбөр тооцоог Гүйцэтгэгчийн Хаан банкны 5529076723 тоот дансанд үйлчилгээний нэхэмжлэхийн дагуу бүрэн төлнө.

3.3. Энэхүү Гэрээгээр хийж гүйцэтгэх ажлын нийт хөлсөнд НӨАТ, болон холбогдох татвар хураамж, захиалгат ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой бүхий л зардал төлбөрүүд /*тээвэрлэлт, туслах тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд ашиглагддаг машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, засварын ажил, угсралт, тохируулгын ажил болон холбогдох татвар, ажилчдын цалин* .../ бүрэн багтсан болно.

3.4. Гэрээнд тусгагдаагүй ажил эсвэл Захиалагчаас тусгайлан бичгээр зөвшөөрөл өгөөгүй аливаа ажлын зардлыг Захиалагч тал хариуцахгүй.

3.5. Төлбөр хойшлуулах: Ажлыг доголдолтой гүйцэтгэсний улмаас Гүйцэтгэгч уг доголдлыг арилгахаар өөрийн зардалаар Ажил дахин гүйцэтгэснийг Захиалагч шаардлага хангасан гэж үзэн хүлээж авах өдрөөс хойш ажлын 3 дахь хоногийг хүртэл, эсвэл Захиалагч нягтлан үзэх шаардлагатай бол ийнхүү шалгаж дуусах хүртэл хугацаанд хойшлуулна.

3.6. Гэрээний 3.1-т дурдсан төлбөрийг шилжүүлэх санхүүгийн үндсэн баримт нь Ажил хүлээлцсэн акт, нэхэмжлэх болон зарлагын падаан, НӨАТ-н баримт байх бөгөөд, эдгээр баримт бүрдээгүй тохиолдолд Захиалагч нь ямар нэгэн алданги торгууль хүлээхгүй болно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Ажлыг Гэрээнд болон Хавсралт №1-д заасан ажлын даалгавар болон Захиалагчийн захиалгын дагуу, гэрээнд заасан хугацаанд багтаан, Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандарт, норм, дүрэм журамд нийцүүлэн, чанарын болон мэргэжлийн өндөр түвшинд, холбогдох стандартын шаардлага бүрэн хангасан түвшинд, эрхийн болон биет байдлын доголдолгүй, мэргэжлийн ажилтнуудаар, алдаа дутагдал, аливаа доголдолгүйгээр хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.2 Гэрээний хүчинтэй хугацаанд Гүйцэтгэгчийн энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох, түдгэлзэх, цуцлагдах зэргээр хүчин төгөлдөр бус болох, сунгалт хийхтэй холбоотой хугацаа шаардагдах эсвэл цаашид дахин сунгагдаагүй тохиолдолд Захиалагчид энэ талаар нэн даруй урьдчилан мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү Захиалагчид мэдэгдээгүйгээс учирсан аливаа хохирол, эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгууль зэргийг Гүйцэтгэгч бүрэн хариуцаж, Захиалагчийг хохиролгүй болгох үүрэгтэй.

4.3 Захиалгат ажлыг гүйцэтгэх үед ажиллах өөрийн ажилтнуудын /туслан гүйцэтгэгч байгаа бол тэдгээрийн/ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцах



*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.*

бөгөөд, томилолт, тээвэрлэлт, угсралт суурилуулалт зэрэг бүхий л явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, аюулгүй ажиллагааны зардал болон автомашины багаж хэрэгслийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг ханган ажиллана.

4.4 Захиалагчийн өмчлөлд аливаа гэмтэл, доголдолгүй үр дүнг шилжүүлэх үүрэгтэй.

4.5 Ажлыг хүлээн авах үед эсхүл Гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэсэн Ажил нь эрхийн болон биет байдлын доголдолтой, Захиалагчийн шаардлагад нийцэхгүй, Гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй байна гэж Захиалагч үзвэл Захиалагчаас тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэх;

4.6 Захиалагчийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй/дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй байх үүрэгтэй бөгөөд Ажлыг гүйцэтгэхэд туслан гүйцэтгэгч ажиллуулах тохиолдолд туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

4.7 Ажлыг Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд заасан шаардлагыг хангаж гүйцэтгэсэн тохиолдолд Гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу Захиалагчаас төлбөр төлөхийг шаардах;

4.8 Гэрээний хүчинтэй хугацаанд Ажлын үнийг аливаа үндэслэлээр нэмэгдүүлэхгүй байх.

4.9 Том машины тос тосолгоо, нефть болон химийн ямар нэгэн бодис зэрэг цэвэрлэх байгууламжид хор хөнөөл учруулж болзошгүй бохир усыг соруулахгүй байх эрхтэй.

4.10 Бохир усны машин, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлах, урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

4.11 Гүйцэтгэгч нь зөвхөн ажлын цагаар ажиллах бөгөөд бохир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авсан байх, бохир ус соруулсан тэмдэглэгээ, хөтөлгөөг сар, өдрийг тодорхой хөтөлж Захиалагчаар гарын үсэг заавал зуруулан 1 хувийг Захиалагчид өгөх үүрэгтэй.

4.12 Захиалагчаас бохир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авснаас хойш ажлын 3 өдрийн дотор ирж бохир ус соруулах, тээвэрлэх ажлыг гүйцэтгэнэ. Хэрвээ бохир ус соруулах , тээвэрлэхэд саад гарвал дуудлага авсан өдөртөө нөгөө талд хариу мэдэгдэнэ.

4.13 Гүйцэтгэгч нь Захиалагчийн бохир усыг Цагаан хад суурьшлын бүсээс Ханбогд сум дахь цэвэрлэх байгууламжид тээвэрлэж буулгана.

4.14 Захиалагчийн ая тухтай орчныг бүрдүүлэх зорилготой бохир ус соруулах, тээвэрлэх ажлыг найдвартай тасралтгүй гүйцэтгэх үүрэгтэй.

4.15 Гүйцэтгэгч нь өөрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ХАБЭА-ны ажилтантай байх, үйл ажиллагаандаа, ХАБЭА-н дүрэм журам, Аюулгүй ажиллагааг чанд мөрдөн, Галын аюулаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Гүйцэтгэгчийн ажилтнууд нь Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа баримтлах дүрэм журам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг чанд мөрдөж ажиллах, аюултай, осолтой байж болзошгүй тоног төхөөрөмж, хэрэгслүүдтэй харьцах шаардлага үүссэн тохиолдолд тухайн тоног төхөөрөмж, хэрэгслүүдтэй харьцдаг мэргэжлийн ажилтны зааварчилгааг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд тийнхүү мөрдөөгүйн улмаас үүссэн хариуцлагыг Гүйцэтгэгч, түүний ажилтан өөрөө хариуцна.

4.16 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа талбайн бусад хэсэгт хохирол учруулахгүй байх үүрэгтэй бөгөөд Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад Захиалагч болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол уг хохирлыг бүрэн хариуцна.

4.17 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаа, Гэрээний үүргийн зөрчлөөс шалтгаалан Захиалагч нь Гэрээнээс татгалзсан тохиолдолд дараагийн ажил гүйцэтгэгчийг олох хүртэл хугацаанд ажил тасалдсантай холбоотойгоор энэхүү Гэрээний нийт үнийн дүнгийн 10%-тай тэнцэх хэмжээний торгуулийг, урьдчилгаа төлбөрийн хамт буцаан төлнө.

4.18 Гэрээний хүчинтэй хугацаанд Ажлын үнийг аливаа үндэслэлээр нэмэгдүүлэхгүй байх.

4.19 Гүйцэтгэгч талын буюу түүний ажилтны буруутай үйлдлээс болж Захиалагчийн эд хөрөнгөд ямар нэгэн хохирол үүссэн тохиолдолд учирсан хохирлыг тооцож хариуцан барагдуулна.

4.20 Энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлэх үүрэгтэй.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ,ҮҮРЭГ



*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.*

5.1. Захиалагч нь Монгол Улсын Иргэний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж, дүрэм журамд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2. Захиалагч нь үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагатай бохир ус соруулах гэрээ байгуулснаар бохир ус соруулах эрх үүснэ.

5.3. Захиалагч нь бохир соруулах цооног нүхэндээ хог хаягдал, царцдаг бөглөрдөг зүйлсийг хийхгүй байх шаардлагатай ба эдгээрийг бий болохоос хамгаалах тор, шүүр зэргийг байршуулах үүрэгтэй.

5.4. Захиалагч нь Гүйцэтгэгч талын ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтныг эзэмшил газартаа саадгүй нэвтрүүлж, сорогч автомашин ажил гүйцэтгэхэд тохиромжтой аюулгүй зогсоол гаргасан байна.

5.5. Захиалагч нь бохир соруулах дуудлагаа 80828272 дугаарт ажлын цагаар өгөх бөгөөд дуудлагыг 48 цагийн өмнө өгч байна.

5.6. Захиалагч талын буруутай үйлдлээс болж бохир соруулах машин тоног төхөөрөмжид хохирол үүссэн тохиолдолд засвар үйлчилгээний зардлыг хариуцна.

5.7. Гүйцэтгэгч тал нь бохир ус соруулсан тэмдэглэгээ, хөтөлгөөг сар, өдрийг тодорхой хөтөлж, кемпээр орсон гарсан хөдөлгөөнөө харуулаар давхар тэмдэглүүлж, Захиалагчаар буюу кемп менежерээр гарын үсэг заавал зуруулах бөгөөд тухайн баримтыг талууд тус бүр 1, 1 хувийг хадгална.

5.8. Гүйцэтгэгч Ажлыг Гэрээнд заасан нөхцөлийн дагуу, хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд Ажлын хөлсийг Гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу төлөх үүрэгтэй.

5.9. Энэ зүйлийн 6.1-д заасан баримтыг үндэслэн Талууд сар бүрийн 5-ны дотор өмнөх сарын бохир ус соруулж, тээвэрлэсэн байдлыг дүгнэж, тооцоо нийлсэн актыг үйлдэж байна.

5.10. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол Захиалагч Гэрээг нэг талын санаачлагаар цуцалж, учирсан зардал /хууль зүйн болон үйл ажиллагааны, бусад/, хохирлоо нэхэмжлэн авах;

5.11. Хэрэв ажлын доголдлыг арилгах, засварлах шаардлагыг Гүйцэтгэгч биелүүлээгүй бол Гэрээг цуцалж, өөр гуравдагч этгээдээр уг доголдлыг арилгуулах, гүйцэтгүүлэх бөгөөд үүнтэй холбогдон гарсан бүх зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх;

5.12. Ажилд байгаа дутагдал, алдаа, бүрэн бус байдлаас үүдэн учирсан хохирол, зардлыг нөхөн төлүүлэхээр Гүйцэтгэгчээс шаардах;

5.13. Энэхүү Гэрээнд заасан аливаа үндэслэлээр Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаа, Гэрээний үүргийн зөрчлөөс шалтгаалан Захиалагч нь өөрийн санаачилгаар Гэрээнээс татгалзах эрхтэй бөгөөд Захиалагч ийнхүү Гэрээнээс татгалзсан тохиолдолд дараагийн ажил гүйцэтгэгчийг олох хүртэл хугацаанд ажил тасалдсантай холбоотойгоор энэхүү Гэрээний нийт үнийн дүнгийн 10%-тай тэнцэх хэмжээний торгуулийг Гүйцэтгэгчээр төлүүлэх, суутган авах эрхтэй байна. Энэхүү торгууль нь Захиалагчийг энэхүү Гэрээ болон хуульд заасан үндэслэлээр өөр бусад хохирол нэхэмжлэх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

5.14. Гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 Захиалагч нь дараах нөхцөлд нэг талын санаачлагаар Гэрээг дуусгавар болгох эрхтэй:

6.1.1. Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэл, Ажлын үр дүн нь Гэрээнд заасан шаардлагад нийцээгүй эсвэл шаардлага хангахгүй байна гэж Захиалагч үзсэн;

6.1.2. Ажлын явцад Гүйцэтгэгчийн зүгээс зөрчил, дутагдал гаргасан бөгөөд уг зөрчил, дутагдлыг арилгах хугацаа тогтоож өгсөн боловч Гүйцэтгэгч нь уг хугацаанд тухайн зөрчил, дутагдлыг арилгаж чадаагүй;

6.1.3. Захиалагчийн зүгээс Ажлыг бүрэн буюу хэсэгчлэн зогсоохоор шийдвэрлэсэн;

6.1.4. Хууль буюу Гэрээнд заасан бусад үндэслэл.



*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.*

6.2 Талуудын аль нэг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талд хохирол учруулсан тохиолдолд аль буруутай тал нь хохирлыг нөхөн барагдуулна.

6.3 Захиалагч сар бүрийн 10-ны дотор багтаан төлбөрөө төлөх бөгөөд уг хугацаанд тооцоо хийгээгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

6.4 Гүйцэтгэгч нь Захиалагчаас бохир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авснаас хойш ажлын 3 өдрийн дотор ирж бохир ус соруулах, тээвэрлэх ажлыг гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгэвэл зохих үүргийн үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө.

6.5 Гүйцэтгэгчийн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буруутай үйлдлээс Гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон тохиолдолд, түүнчлэн баталгаат хугацаанд захиалгат ажилд доголдол илэрсэн тохиолдолд Захиалагч үүнтэй холбогдон учирсан хохирол, зардлаа Гүйцэтгэгчээс нэхэмжлэх эрхтэй байна.

6.6 Гэрээг 6.1 хэсэгт заасны дагуу хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон тохиолдолд Захиалагч нь Гэрээг тийнхүү дуусгавар болох хүртэл хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн Ажлын үр дүнгээс хүлээж авах боломжтой хэсгийг шийдвэрлэж, тэдгээр Ажлын бодит гүйцэтгэлд тохирох төлбөрийг Гүйцэтгэгчид олгох ба үүнээс бусад аливаа хохирол, алданги торгууль, төлбөрийг төлөх үүрэг хүлээхгүй.

6.7 Гүйцэтгэгч Гэрээнд заасан хугацаанд захиалгат ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөөгүй тохиолдолд ийнхүү хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 /тэг аравны тав/ хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагч талд төлнө.

